

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН СУДАЛГАА

Д.Булган

Хууль зүйн доктор, дэд профессор
цагдаагийн дэд хурандаа

Г.Ариунгэрэл
Магистр, судлаач

Товч агуулга: Энэхүү өгүүллэгийн гол агуулга нь 1-т; “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” 1996, 2015 оны хуулийн харьцуулалт, 2-т; “Эрүүгийн хууль”-ийн харьцуулалт, 3-т; “Захиргааны хариуцлагын тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-ийн харьцуулалт, 4-т “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам” болон бусад холбогдох дүрэм, журмуудыг харьцуулан судаллаа.

Түлхүүр үгс: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил, эрх зүйн зохицуулалт.

Оршил

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан “Амьд явах эрхтэй; 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэдэг нь зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг” хэлнэ гэж тодорхойлсон. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийг заасан бөгөөд “замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих”, “замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах зорилгоор замын хөдөлгөөнийг зохицуулах”¹ талаар заажээ.

Эдгээр заалтууд нь иргэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил, ослоос ангид байж эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн гол эрх зүйн зохицуулалт юм. Уг хууль нь замын хөдөлгөөний зохион байгуулалт, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж, 2015 онд шинэчлэн батлагдсан.

Өнөөгийн нийгэмд хамгийн их эрсдэл учруулж байгаа зүйл бол авто машины осол, аваар бөгөөд зөрчил гарахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалалтын бүс, малгай, аюулгүйн бүс хэрэглэхгүй байх, хурд хэтрүүлэх, гар утсаар ярих, нүүрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг тохируулахгүй байх нь жолоочийн ур чадварт шууд нөлөөлж, зам тээврийн осол гардаг. Мөн зам тээврийн ослын шалтгаан нь замын нөхцөл байдал, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл, жолоочийн буруугаас, орчны нөлөөлөл гэсэн зүйлүүдээс хамааралтай.

¹ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 он, Төрийн мэдээлэл №01.

Ийнхүү шалтгаан хүчин зүйлийг нь оновчтой тодорхойлсноор энэ төрлийн үзэгдэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг зөв тодорхойлох, зам тээврийн осол, хэргийн гаралтыг тогтоон барих, бууруулах арга хэмжээг төлөвлөн авах боломжтой болох юм.

Манай улсад 5 жилд зам тээврийн ослын улмаас 2443 хүн нас барж, 18456 хүн гэмтэл авч байна. Зам тээврийн ослоос нас барсан хүмүүсийн 75.0 хувь, гэмтсэн хүмүүсийн 35 гаруй хувь нь орон нутгийн хатуу хучилттай замд гарсан ослоос шалтгаалсан байна. Замын тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу эдийн засаг, улс төр, эрх зүй, соёл, хүн ам зүй, техник, технологийн хөгжлөөс хамааран хувьсан өөрчлөгдөж байна. Иймд орон нутгийн автозамд зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын онолын үндсийг судалж, үр дүнтэй зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалт, бодлого шийдвэрт хүрэх, аймаг, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үүрэг оролцоог тодорхойлох, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхээр энэхүү сэдвийг сонгон авч судаллаа.

Энэхүү өгүүллийн зорилго нь зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, холбогдох түүний агуулга, шинэчлэл, тэдгээрийн зааг ялгааг гаргаж, судалгааны эргэлтэд оруулах, хөгжүүлэх, практикт сайжруулах арга замыг бий болгох, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэх явдал юм.

Үндсэн хэсэг. Зам тээврийн осол, зөрчил гарахад жолоочийн мэдлэг ур чадвар муу, замын нөхцөл байдал, халтиргаа, гулгаа, явган зорчигчийн буруутай үйл ажиллагаа, техникийн бүрэн бус шаардлага хангахгүй, хуучирч муудсан авто машинууд, шаардлага хангахгүй гэрлэн дохио, тэмдэг, тэмдэглэлгүй уулзвар гарц, зам, авто замын эвдрэл гэмтэл, алдаатай зохион байгуулалт, гэрэлтүүлэггүй зам орчин, эрх зүйн зохицуулалтын хийдэл зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах олон улсын гэрээ, конвенцуудаас гадна үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актуудыг баримтлан ажилладаг.

Монгол Улсын нэгдэн орсон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаарх олон улсын гэрээ, конвенц²-д Замын хөдөлгөөний тухай 1968 оны Вений Конвенц, Замын дохио, тэмдгийн тухай 1968 оны Вений Конвенц, Замын хөдөлгөөний тухай 1968 оны Конвенцын нэмэлт болох 1971 оны Европын хэлэлцээр, Замын дохио, тэмдгийн тухай 1968 оны Конвенцын нэмэлт болох 1971 оны Европын хэлэлцээр зэрэг болно. Монгол Улс дээрх Конвенцад нэгдэн орох тухай Монгол Улсын Их хурлаас 1997 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Замын хөдөлгөөний тухай болон Замын дохио, тэмдгийн тухай Вений Конвенцуудыг хүлээн зөвшөөрч нэгдэн орох тухай хууль соёрхон баталж³, 1998 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс тус Конвенцууд Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн юм.

² Замын хөдөлгөөний тухай болон замын дохио, тэмдгийн тухай конвенц. Эмхэтгэсэн Хурцбилэг А, Мөнхжаргал Я. Замын хөдөлгөөн судлалын хүрээлэн. УБ., 2004 он.

³ **Конвенцийг хүлээн зөвшөөрч нэгдэн орох тухай** Монгол Улсын хууль. <https://legalinfo.mn/mn/detail/10102>

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай”⁴, “Автозамын тухай”⁵, “Авто тээврийн тухай”⁶, “Зөрчлийн тухай”⁷, “Эрүүгийн хууль”⁸, “Цагдаагийн албаны тухай”⁹ зэрэг хуулиуд, “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм”, түүнчлэн Монгол Улсын Засгийн газар, яам, тамгын газруудаас батлан гаргасан “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх”¹⁰, “Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох”¹¹, “Автотээврийн хэрэгслийн тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох”¹², “Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын үзлэг явуулах”¹³, “Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх”¹⁴ зэрэг 30 шахам журам автозам, авто тээврийн салбарын тогтолцооны стандартууд батлагдан мөрдөгдөж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөх замын хөдөлгөөний нэгдсэн журмыг Замын хөдөлгөөний дүрмээр тогтооно гэж заасан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 оны 09 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр зам тээврийн осол буурсан¹⁵ талаар Тээврийн цагдаагийн албанаас гаргасан судалгаа байдаг. Тиймээс дараах хүснэгтээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн (1996, 2015) харьцуулалтыг хийлээ.

Хүснэгт 1. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн харьцуулалт

№	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /1996/	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /2015/
1	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулахад оршино.

⁴ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга). 2015.

www.legalinfo.mn

⁵ Автозамын тухай хууль. 1998. Төрийн мэдээлэл. № 2.

⁶ Авто тээврийн тухай. 1999 он.

⁷ Зөрчлийн тухай хууль. (шинэчилсэн найруулга). Төрийн мэдээлэл. 2016., № 08.

⁸ Эрүүгийн хууль. (шинэчилсэн найруулга) 2015. Төрийн мэдээлэл 2016., № 07.

⁹ Цагдаагийн албаны тухай хууль. (шинэчилсэн найруулга) 2017., Төрийн мэдээлэл. № 08.

¹⁰ Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/171, А/496 дугаар тушаал. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам.

¹¹ Хууль зүйн сайдын 2014 оны А/158 дугаар тушаал. Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах

¹² Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаал. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам.

¹³ Дэд бүтцийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 235/209 дугаар хамтарсан тушаал. Тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын үзлэг явуулах журам.

¹⁴ Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 201 дүгээр тушаал. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм

¹⁵ Монгол Улс дахь зам тээврийн осол зөрчлийн статистик үзүүлэлт. ЗЦГ- УБ, 2016 он, 48 дахь тал.

2	-	3.1.6."зам тээврийн осол" гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг;
3	15 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх 2/ иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах;	9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх, үүрэг 9.2.2.зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны төлөвлөгөө батлах;
4	16 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын алба, байцаагчийн бүрэн эрх	8.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллага дараах үүргийг гүйцэтгэнэ:
5	4/аж ахуйн нэгж, байгууллага нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг ажиллагсад болон суралцагсад судлуулж, ослоос урьдчилан сэргийлэх ажил зохиож байх;	13.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, хуулийн этгээд дараах үүргийг хүлээнэ: 13.2.1.Замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх;

Хүснэгтээс харахад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай 1996 оны хуульд “зам тээврийн осол” гэсэн нэр томъёог тодорхойлоогүй боловч зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг ЗХАБ хангах гэж тодорхойлжээ. Харин 2015 оны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар “урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө” боловсруулан ажиллахаар заасан нь шинэлэг зохицуулалт болжээ. Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5-д “харьяа нутаг дэвсгэрийнхээ зам, замын байгууламж гэрэлтүүлэг, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчил, иргэдийн санал, гомдлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авхуулах¹⁶”-аар заасан нь чухал ач холбогдолтой болжээ. Үүнээс гадна замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд урьд зохицуулагдаж байгаагүй дараах шинэлэг заалтууд оржээ. Үүнд:

- Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хугацаатай байхаар заасан нь жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэх тогтолцоог бий болгосон.

¹⁶ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. 2015 он.
<https://legqinfo.mn/mn/detail/11224>. 2022.03.22

- Олон улсын жолооны үнэмлэхийн талаар заасан нь урьд зохицуулагдаагүй боловч хэрэглэгдэж байсан харилцааг зохицуулсан.
- УИХ, ЗГ, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх, үүрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар заасан нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.
- Иргэдийн эрх, үүргийг тодотгож өгсөн,
- Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах болон бэлэн бус хэлбэрээр торгууль ногдуулах, зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмыг холбогдох эрх бүхий байгууллагаас батлан гаргахаар тусгажээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах гол механизм бол замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг тогтоосон “Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль”-д тусгайлан заасан явдал юм. Дараах хүснэгтээр Эрүүгийн хуульд заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн зүйлчлэл, хүлээлгэх хариуцлагыг харьцуулан авч үзье.

Хүснэгт 2. Эрүүгийн хуулийн (2002, 2015) харьцуулалт

№	Эрүүгийн хууль /2002/	Эрүүгийн хууль /2015/
1	215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих	27.10 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих 27.10.2. Энэ гэмт хэргийг:
2	221 дүгээр зүйл. Согтуурсан буюу мансуурсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах	2.1. согтуурсан, мансуурсан үедээ; 2.2. тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн;
3	221 дугаар зүйл. Бүрэн биш тээврийн хэрэгслийг ажилд гаргах, жолоодох эрхгүй хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах	2.3. хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж; 2.4. их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол ... ял шийтгэнэ.
4	216 дугаар зүйл. Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах	27.11 дүгээр зүйл. Авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах ЗТХ-ийн 14.7.18-д “Зам тээврийн осолд холбогдсон жолооч ослын газрыг орхиж зугтаасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус заасан.
5	218 дугаар зүйл. Тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг	27.9 дүгээр зүйл. Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих

	чанаргүй засварлах, ашиглалтад оруулах	
6	219 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг эвдэх, гэмтээх	ЗТХ-ийн 14.5.6-д “Зам, эсхүл замын зорчих хэсэгт эвдрэл, гэмтэл учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.
7	222 дугаар зүйл. Жолоогоо бусдад шилжүүлэх	ЗТх-ийн 14.7.4-т “Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.
8	223 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийг тээврийн хэрэгсэл жолоодуулах. ¹⁷	

Хүснэгтээс харахад Эрүүгийн хуулийн /2002 он/ 211 дүгээр зүйлд заасан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих”¹⁸ гэмт хэргийг хэвээр нь хуульчилсан бөгөөд хүлээлгэх хариуцлагыг чангатгасан байна. Мөн ЭХ-ийн 222 дугаар зүйл “Жолоогоо бусдад шилжүүлэх”, 223 дугаар зүйл “Авто тээврийн хэрэгслийг тээврийн хэрэгсэл жолоодуулах” гэмт хэргүүд хасагдаж, “Зам, эсхүл замын зорчих хэсэгт эвдрэл, гэмтэл учруулсан”, “Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн”, “Жолооч Замын хөдөлгөөний дүрэмд заасан баримт бичиггүй хүнд тээврийн хэрэгслийг шилжүүлсэн” зэрэг зөрчлийг Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр заажээ. Энэ нь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд нь тохирсон хариуцлага хүлээлгэж буй хэлбэр юм.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил”-ийг Захиргааны хариуцлагын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /2015/-д тусгасан байсныг 2016 оны 9 сарын 1-ний өдрөөс Зөрчлийн тухай хуулиар зохицуулж, хариуцлага хүлээлгэхээр болсон.

“Зөрчлийн тухай хууль”-ийн арван дөрөвдүгээр бүлэгт “тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил”-ийг заагаад 8 хэсэгт хуваан зохицуулж, агаарын болон төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг нэг бүлэгт хамруулжээ. Уг хуулийн 14.7-т “замын

¹⁷ Эрүүгийн хууль (2002)-ийн 223 дугаар зүйлийн 223.1-т “Авто тээврийн хэрэгслийг ашиглан шамшигдуулах зорилгогүйгээр авч зугтаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” гэж заасан.

¹⁸ Эрүүгийн хууль. 2002 он. <https://legalinfo.mn/mn/detail/12172>

хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил"-ийн талаар заасан бөгөөд 57 зүйл бүхий зөрчлүүдийг тусгасан. Үүнийг дараах хүснэгтээр харьцуулан судалж үзье.

Хүснэгт 3. Захиргааны хариуцлагын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн харьцуулалт

№	Захиргааны хариуцлагын тухай хууль	Зөрчлийн тухай хууль
1	1 .Согтууруулах ундааны зүйл уусан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явсан, эсхүл согтууруулах ундааны зүйл уусан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол ... шийтгэл ногдуулна.	14.7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 1.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2	2.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон бол 25000-50000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.	2.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл эрх нь дуусгавар болсон хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3	3.Ашиглахыг хориглосон, гэмтэлтэй буюу зохих зөвшөөрөлгүйгээр өөрчлөн тоноглосон тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон, ... бол ... шийтгэл ногдуулна.	57.Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргаас харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт
4	4.Явган болон унадаг дугуй, ердийн хөсгөөр зорчигч этгээд хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн бол 100-8000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.	тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5	5.Жолооч болон тээврийн байгууллагын ажилтан хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь ... шийтгэл ногдуулна.	Ийнхүү Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчихтэй холбоотой нийт 57 зөрчлийг тусгаж зохицуулсан байна.
6	6.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд 7-30	

	хоног баривчлах шийтгэл ногдуулна.	
7	7.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг 5000-30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.	

Дээрх хүснэгтээс харахад Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар 7 зүйл бүхий зөрчилд хариуцлага хүлээлгэж, 50000 хүртэл төгрөгөөр торгож, 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар эрх хасах шийтгэл ногдуулж байсан. Харин Зөрчлийн тухай хууль батлагдсанаар торгуулийн хэмжээ нэмэгдэж, 3 сараас 2 жил хүртэл хугацаагаар эрх хасах, 7-30 хоног баривчлах шийтгэл, жолоочийн бүртгэлийн оноо хасах арга хэмжээг ногдуулж байна. Энэ нь өмнөх хуульд заасан хариуцлагыг чангатгаж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг нарийвчлан заасан нь харагдаж байна.

Дээрх хууль тогтоомжоос гадна замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой бусад журмуудыг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Хууль зүйн сайдын А/187 дугаар тушаалаар “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам”;
2. Хууль зүйн сайдын А/190 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”, хоёрдугаар хавсралтаар “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам” /ХЗДХС-ын 2019 оны 101 дүгээр тушаалаар шинэчлэгдсэн/;
3. Хууль зүйн сайдын А/186 дугаар тушаалаар “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, эрх сэргээх журам” тус тус батлагдсан.

Мөн замын цагдаагийн албанд ашиглагддаг “Согтуурал шалгах багаж” болон “Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл”-ийг ашиглах стандартыг Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн төвийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталсан.

Эдгээр журмуудаас “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам” (2015,2019)-удыг харьцуулан дараах хүснэгтээр үзүүлье.Үүнд:

Хүснэгт 4. Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам¹⁹.

№	Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам. /Хууль зүйн сайдын 2015 оны а/190 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт/	Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам /Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны а/101/
1	1.1.Энэ журмын зорилго нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэдтэй харилцах харилцаа, замын хөдөлгөөнийг зохицуулж, хяналт тавих, эргүүлийн чиглэлийн хяналтын бүсийг тогтоох, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хянан шийдвэрлэх, зам тээврийн ослын газрыг хамгаалах, тээврийн хэрэгслийг дайчлах, эрэн сурвалжлах, албадан зогсоох явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.	1.1.Энэ журмын зорилго нь эргүүлийн чиглэлийн бүсийг тогтоох, хяналт тавих арга, хэлбэр, зам, замын байгууламж, замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэл, тээврийн хэрэгсэлд хяналт тавих, зөрчлийг бүртгэж, шийдвэрлэх, зам тээврийн ослын газрыг хамгаалах, тээврийн хэрэгслийг дайчлах, албадан зогсоох, эрэн сурвалжлах, тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх, замын хөдөлгөөнд хяналт тавихад хөтлөх бүртгэл, судалгаа хийхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
2	Хоёр. Эргүүлийн чиглэлийн хяналтын бүс, арга хэлбэр, чиглэл, алба хаагчдын үйл ажиллагаа	Хоёр. Эргүүлийн чиглэлийн бүсийг тогтоох, хяналт тавих арга, хэлбэр
3	Гурав. Замын хөдөлгөөнийг зохицуулах	Гурав. Зам, замын байгууламж, замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэл, тээврийн хэрэгсэлд хяналт тавих
4	Дөрөв. Замын хөдөлгөөнд хяналт тавих, зөрчлийг илрүүлэх, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагаа	Дөрөв. Зөрчлийг бүртгэж, шийдвэрлэх
5	Тав. Зам тээврийн ослын газрыг хамгаалах	Тав. Зам тээврийн ослын газрыг хамгаалах
6	Зургаа. Тээврийн хэрэгслийг дайчлах	Зургаа. Тээврийн хэрэгслийг дайчлах
7	Долоо. Тээврийн хэрэгслийг албадан зогсоох	Долоо. Тээврийн хэрэгслийг албадан зогсоох

¹⁹ Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оныОБ дугаар сарын 07-ны өдрийн А/101дугаар тушаалын хавсралт.
<https://legalinfo.mn/mn/detail?lawid=14469>

8	Найм. Тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах	Найм. Тээврийн хэрэгслийг эрэн сурвалжлах
9	Ес. Замын хөдөлгөөнд хяналт тавихад хөтлөх бүртгэл, судалгаа, маягтын загвар	Ес. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах
10		Арав. Замын хөдөлгөөнд хяналт тавихад хөтлөх бүртгэл, судалгаа

Эдгээр журмыг харьцуулан үзэхэд 2019 оны журамд нэлээд зохицуулалтыг нэмж тусгасан байна. Тухайлбал, журмын гурав дахь хэсгийн агуулга хоорондоо ялгаатай, шинэ зохицуулалтыг тусгажээ. Энэ хэсэгт ЗХАБ эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг тусгасан байна. Үүнд: Тус журмын 3.2.4.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр зам сэтэлсэн, орц, гарц гаргасан болон замын хөдөлгөөн зохицуулах техник, хэрэгслийг халхлах зэргээр замын хөдөлгөөнд оролцогчдод аюул, саад учруулах зүйлийг зам дээр буюу түүний ойролцоо байрлуулсан эсэх г.м.

Мөн шинээр баталсан журам бол “жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам²⁰” юм. Тус журам нь Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187 дугаар тушаалаар баталж, мөн оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж ирсэн. Тус журмын 2.1-т “Жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомж,” дүрэм, журам, стандарт зөрчсөн үйлдэлд нийгэмд учирч болзошгүй хор, уршгаас шалтгаалан зөрчлийн 1-5 оноо хасна”, 2.2-т “жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо дууссан тохиолдолд тухайн жолоочийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүйд тооцно” гэж тус тус заажээ.

“Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх журам”²¹-д зааснаар “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн зөрчлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан бол Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, хөдөлгөөний сахилга, соёл, архи, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг сурталчлах, урьдчилан сэргийлэх 4 цагийн, гэмт хэрэг, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх 2 цагийн, нийт 6 цагийн сургалтад хамрагдсан” байхаар зохицуулсан. Энэхүү заалтаас харахад зөрчил гаргасан жолоочийг зөрчлийн шинжээс нь хамаарч урьдчилан сэргийлэх сургалтад хамрагдахаар заасан байна. Гэхдээ 4-6 цагийн сургалтад хамрагдсанаар дахин зөрчил гаргахгүй байх, сургалт үр дүнтэй байх талаар анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

²⁰Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам. Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187 дугаар тушаалын хавсралт
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11296>

²¹ Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх журам. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/142 дугаар тушаал.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=208581&showType=1> 2022.04.04

Дүгнэлт

Тээврийн цагдаагийн албанаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон ажил арга хэмжээг цаг хугацааны хувьд харилцан адилгүй байдлаар зохион байгуулж ирсэн. Гэсэн хэдий ч улсын хэмжээнд зам тээврийн осол, зөрчлийн 97.9% нь жолоочийн буруутай үйлдлээс улбаатайгаар гарч байгаа нь нэг талаараа жолоочийн эрх олгох сургалтын чанар, нөгөө талаараа жолооч нарын ухамсар муу, хөдөлгөөний соёл төлөвшиж чадаагүй, үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байгаатай холбон үзэж болохоор байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад жолоочийн үүрэг, хариуцлагыг зохицуулсан хууль, эрх зүйн орчин зохих хэмжээгээр бүрдсэн ч түүний хэрэгжилт, үр нөлөөг тодорхойлж, судлах шаардлагатай байна. Ийнхүү эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цагдаагийн байгууллагаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой нэлээдгүй эрх зүйн зохицуулалт шинэчлэн батлагдаж гарсан бөгөөд хэрэгжээд төдийлөн удаагүй ч цаашид үр нөлөөг нь улам дээшлүүлэх нь зүйтэй байна. Тиймээс эдгээр эрх зүйн зохицуулалтын сайн болон доголдолтой талыг нээн илрүүлж, тухайн асуудлыг практикт зөв хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

Санал

1. Зөрчлийн тухай хуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоонд “зөрчлийн оноо хасах” талаар тусгаж, зохицуулах.

2. Зөрчлийн тухай хуульд заасан зарим төрлийн ЗХАБ-ын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх. Тухайлбал, Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэг үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол торгох шийтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, жолооч согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийг 3-аас дээш удаа давтан гаргасан тохиолдолд албадан эмчилгээнд хамруулж, сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлтийг үндэслэн 14.4.3-д заасан хариуцлага хүлээлгэх.

3. “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, урьдчилан сэргийлэх сургалтыг цагийг 16 цаг болгох, өдрийн сургалтад хамруулах, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх зайлшгүй байна.